

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын  
Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл /2018-05-01/**

Ажлын хэсгийн 46 дугаар хуралдаан 2018 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн 10.00 цагт Пума Империа зочид буудлын 2 давхарын хурлын танхимд зохиогдов.

Ажлын хэсгийн хуралдаанд Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Ажлын хэсгийн ахлагч Б.Энх-Амгалан, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын референт Э.Сумъяаг орлож ЗГХЭГ-ийн референт Д.Балжинням, Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын газрын дарга Г.Түвдэндорж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Б.Дэлгэржаргал, ахлах мэргэжилтэн Ч.Цогтбаатар, БОАЖЯ-ны мэргэжилтэн Ц.Хосбаяр, Татварын ерөнхий газрын татварын байцаагч Ж.Батцэнгэл, Ашигт малтмалын газрын мэргэжилтэн Г.Оюунтуяа, Хил хязгааргүй алхам ТББ-ийн тэргүүн Н.Баярсайхан, Байгаль эхийн аврал сан ТББ-ийн тэргүүн Б.Наранцэцэг, Ил тод сан ТББ-ийн гүйцэтгэх захирал Д.Цэрэнжав, Хөвсгөл далайн эзэд ТББ-ийн тэргүүн Б.Баярмаа, Миний монголын газар шороо хөдөлгөөний гүйцэтгэх О.Отгонсайхан, Хариуцлагатай уул уурхайн санаачилга ТББ-ийн ТУЗ-ын дарга Д.Сүхбаатар, МБОИЗ-ийн Удирдах зөвлөлийн гишүүн Б.Батболд, Транспаренси интернэйшнл Монгол байгууллагын ерөнхийлөгч Л.Төр-од, Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Д.Энхболд, Алт үйлдвэрлэгчдийн холбооны гүйцэтгэх захирал Э.Энхбат, Бороо гоулд ХХК-ын санхүү бүртгэлийн менежер П.Болормаа, Оюутолгой ХХК-ийн ахлах менежер Г.Мөнхбат, Петрочайна дачин тамсаг ХХК-ны нягтлан бодогч н.Болормаа, Багануур ХК, Эрдэнэс таван толгой ХК-ийн төлөөлж Мэндбаяр, Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон нар оролцов. Хуралд ажлын хэсгийн 33 гишүүнээс 24 гишүүн оролцож, ирц 72,7 хувьтай байв.

Мөн хуралдаанд Адам Смит хүрээлэнгийн зөвлөх А.Михайлова, Интерконсалтинг ХХК-ийн захирал Н.Энхжаргал, ажилтан Мягмаржав, төслийн зохицуулагч Б.Золжаргал, ЗГХЭГ-ийн референт Гандэл, шинжээч Цэрэнжүрмэд, болон ажлын албаны харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа, санхүүгийн ажилтан А.Отгонтунгалаг, Мэдээлэлийн технологийн зөвлөх Г.Ганбат нар оролцов.

Хуралдааныг Ерөнхий сайдын ахлах зөвлөх Б.Энх-Амгалан нээж, хурлын хэлэлцэх асуудал болон дотоод журмыг танилцуулснаар хурал эхлэв.

Б.Энх-Амгалан: Баярлалаа, Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Бид хурлаа 10 цагаас гэж тохирсон байгаа, шинэ журмын дагуу оролцогч тал бүрээс хамгийн багадаа 7 төлөөлөл ирсэн байх ёстой байгаа. Ингээд хурлаа эхэлье. Цаашдаа хурлаа цагтаа эхэлж, цагтаа дуусдаг байя. Хурлын үйл ажиллагаа нээснийг мэдэгдье. Та бүхнийг ажил төрлөө зохицуулаад ирсэн явдалд баярлалаа. Өнгөрсөн оны 11 дүгээр сард өмнөх, 45 дугаар хуралдаан болсон байна. Энэ онд Монгол улс ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч 2 дахь орноор хүлээн зөвшөөрөгдөж батламжаа авсан мөн ОУ-ын Удирдах хорооны дарга Ерөнхий сайдад мэндчилгээ дэвшүүлсэн байна. Түүнчлэн ОУИТБС-ын ерөнхий захирал Моберг гуай Монголд айлчлах үеэрээ Ерөнхийлөгч болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад бараалхсан байгаа, бид цаашдаа ч улам хамтран ажиллах болно. Энэ оны 5 дугаар сарын 22 нд Их хурлын түвшинд ашиг хүртэгч эздийг ил тод болгох асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулахаар бэлтгэж байна. Энэ нь хууль тогтоох байгууллага болон төрийн эрх барих дээд байгууллагыг татан оролцуулж байгаа юм. Ингээд өнөөдрийн хурлын хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Гишүүд хэлэлцэх асуудлаа санал нэгтгэйгээр баталсан тул нэгдүгээр асуудлын танилцуулгыг сонсоё.

**ХЭЛЭЛЦСЭН нь: ОУИТБС-ын орон нутгийн туршилтын төслийн танилцуулга**

А.Михайлова: Сайн байцгаана уу, та бүхэнд энэ өглөөний мэндийг хүргэе, энэ арга хэмжээнд урьж оролцуулж байгаад баярлалаа. Намайг Михайлова гэдэг, би ОУИТБС-ын орон нутгийн хөтөлбөрийн төслийн менежерээр ажилладаг. Өнөөдрийн хуралдаанаар

орон нутагт хийсэн мэдээлэл харилцааны төслийн үйл ажиллагаа, эндээс гарсан үр дүнгүүд, үүний үндсэн дээр боловсруулж гаргасан төлөвлөгөөний төслийг танилцуулна. Бидний зорилго нь энэхүү төлөвлөгөөн дээр та бүхний саналыг тусгаад ЕСБХБ болон ОУИТБС-д хүргүүлэх юм. Ингээд танилцуулгаар хийх ажлын зорилго, зорилтууд төслийн үйл ажиллагаанд ямар ажлууд хийгдсэн болон төслийн үр дүнгийн талаар ярилцая. Мөн бидний хийсэн мониторинг шинжилгээний үр дүнд ямар зөвлөмж гарсан, ямар сургамжууд байсан талаар танилцуулна.

Бид 2015 онд төлөвлөлтийн ажлыг хийсэн, үүнд Заамар, Бор-Өндөр, Гурвантэс, Дэлгэрэх, Ерөө гэсэн 5 сумыг сонгож авсан. Эдгээр суман дээр хэрэгцээний үнэлгээ хийсэн, үүний дараа стратегиа боловсруулж гаргасан. Үүний дараа 2016 оноос стратегиа хэрэгжүүлэх ажиллагаанд орсон, ингээд өнөөдөр үр дүнгээ танилцуулах шатандаа ирээд байна. Манай төслийн зорилго нь орон нутагт ОУИТБС-ын талаарх мэдлэгийг бий болгох, хоёрдугаарт мэдээлэл түгээх гэсэн хоёр зорилтын дагуу энэ үйл ажиллагаа хэрэгжсэн. Энэ зорилтын хүрээнд хийсэн ажил, гарсан үр дүнгийн талаар Мягмаржав үргэлжлүүлэн танилцуулна.

н.Мягмаржав: Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе. Энэхүү ОУИТБС маань манай улсад хэрэгжээд 10-аад жил болсон боловч сум, орон нутагт төдийлөн сайн хүрээгүй байсан. Бид 2 үндсэн зорилтынхоо хүрээнд ямар ажил хийсэн талаар танилцуулъя. Энэ ажлыг хийхийн тулд мэдээллээ ямар сувгуудаар хүргэх талаар судлаад, орон нутагт мэдээллийн ажилтан байх шаардлагатай юм байна гэж үзээд сум бүрт мэдээллийн ажилтанг авч ажиллуулсан. Нийтдээ сумын дэд зөвлөлд улиралдаа 1,5 сая жилдээ нийт 6 сая төгрөгийн төсөв шаардлагатай гэсэн тооцоог гаргасан. Цаашдаа дээрх 5 сумандаа үргэлжлүүлэн ажиллах цаашлаад 3-5 суманд нэмж хэрэгжүүлэх боломжтой. Ингээд нийтдээ жилдээ 290 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай байна. /Танилцуулгыг хавсаргав/

Б.Энх-Амгалан: За баярлалаа, гишүүдээс танилцуулгын талаар асуулт байна уу?

Д.Цэрэнжав: Манай улсад гаднын хөрөнгөөр төсөл хөтөлбөр хэрэгжихэд заавал төслийн нэгж байгуулдаг эсвэл төлөөлсөн зохицуулагч бий болгодог. Тухайлбал тогтвортой амьжиргаа гэх мэт төслүүд. Орон нутагт төслийн зохицуулагч бий болгох нь тухайн ажил хэрэгжихэд хэрэгтэй байх, нөгөө талдаа түр ч гэсэн ажлын байр бий болж байгаа байх. Гэхдээ энэ нь явуургүй юм бишүү, тэртэй тэргүй уул уурхайн компаниуд өөрсдийгөө сурталчилах асар их хүсэл эрмэлзэлтэй, боломжтой байгаа. Мөн орон нутаг төрийн өмнө хүлээсэн үүрэг байдаг. Энэ мэт асар их боломжууд байхад мэдээллийн ажилтан гэж хүн гаргаад, тэр нь тогтвортой байх уу байхгүй юу, энэ нь хүний амьдралтай холбоотой асуудлыг яах гэж сонгож авсан юм бэ? Ядаж дэд зөвлөлийн нарийн бичгийн дарга байхаар яагаад суулгаж өгөөгүй юм бэ? бид анх л хэлж байсан. Энэ талаар асуумаар байна.

н.Мягмаржав: Бид эдгээр суманд ажиллахад хамгийн их хүндрэлтэй байсан нь таних хүн байхгүй байсан. Төсөл бүхэн санхүүжилттэй үедээ хэрэгжээд санхүүжилт байхгүй болохоор хэрэгжихгүй болдог. Бид ерөнхийдөө тогтвортой байлгах талаар анхаарал тавьсан. Ингээд бид механизм бий болгоё гэж зорьсон, тэр бүтцийн доор нь мэдээллийн ажилтан байх ёстой юм байна. Ерөнхийдөө гурван талт зөвлөл нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, зөвхөн Монголд бий болсон зүйл биш юм. Энэ гурван талын оролцоотой механизмыг бий болгоход орон нутагт мэдээллийн ажилтан байх ёстой юм байна. Ашигт малтмалын тухай хуулийн 48,10 заасны дагуу тайлан гаргах, уул уурхайтай суманд гэрээ байх ёстой байгаа. Тэгвэл үүний нүд чих нь болох хүн нь мэдээллийн ажилтан юм байна гэж харж байна. Энэ нь өнөө маргаашдаа тогтворгүй харагдаж байгаа боловч цаашдаа хамгийн тогтвортой бүтэц юм байна гэж харж байгаа./танилцуулгыг хавсаргав/

Д.Цэрэнжав: Буруу байна, санал нийлэхгүй байна. Өөрийн чинь хэлж байгаагаар орон нутагт хэрэгжиж байгаа санаачилгад бүгдэд нь мэдээллийн ажилтантай хэрэгтэй юм бол бусад хэрэгжиж байгаа бүх ажлууд заавал зохицуулагчтай байх гээд байна, энэ бол

орон нутагт боломжгүй. Энэ бол зөвхөн нэг санаачилга, дахин хэлэхэд компаниуд өөрийгөө сурталчилах, олон нийтэд хүргэх асар их хүсэл боломжтой, их ажил хийж байгаа, механизм гэдэг чинь хүн биш шүү дээ. Маш буруу аргаар явж байна гэж бодож байна, нэгэнт та нар хийж байгаа болохоор одоо яах вэ?

Л.Төр-Од: Танилцуулгаас харахад маш их нүсэр ажил хийсэн байна, баяр хүргэе. Цаашдаа гарсан үр дүнгээ баталгаажуулаад үр нөлөө болгохын тулд санал болгож байгаа үзэл баримтлалыг харахад буруу харагдаж байна. Төслийн нэгж байгуулах, энэ нь донороос санхүүжигдэж явах юм байна. Энэ нь тогтвортой байх байдал, өөрөө өөрийгөө авч явах санхүүжилтийн байдал нь харагдахгүй байна. Санаагаа хэрэгжүүлэхийн тулд баримталж байгаа арга хэмжээ чиглэл чинь буруу юм шиг санагдаж байна. Төслийг эхлүүлж байхад би одоо байгаа орон нутгийн удирдлага болон өөрөө удирдах бүтцийг ашигламаар байна гэдэг саналыг тавьж байсан. Коммуникац гэдэг нь мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээ гэсэн гурван чиг нийлж байж бүрэн орон нутагт бүрэн утгаараа хэрэгжих юм. Одоо байгаа бүтцийг та нар судалж ашигласан уу? өөрөөр хэлбэл суманд ИТХ-д иргэдийн төлөөлөл байдаг, тэд уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн талаар тодорхой хэмжээний үүрэг рольтой, чиг үүрэгтэй гэдгийг нь хууль тогтоомжид заасан байдаг. Мөн багийн түвшинд Иргэдийн нийтийн хурал гэж байгаа. Эдгээрийг түшиглээд явбал төсөвтөө болон хүний нөөцдөө ч ашигтай, ингээд цаашдаа бэхжүүлээд явах боломжтой харагдаж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Энхжаргал: Тайлбар хэлэхэд, танилцуулга дээр нь төсөл гэдэг нь зөвхөн ОУИТБС-ын дэд зөвлөл хариуцсан ажилтан, мэдээлэл хариуцсан нэг ажилтан байх юм. Бүтцийг дараа нь ярих асуудал юм. Бид жил гаруй хугацаанд ТББ-ийнхантай маш идэвхтэй ажилласан, хуучин бүтцийг боломжоороо ашиглахыг оролдсон. Гурвантэс суманд олон жил ажиллаж байгаа Баярсайхан гишүүнтэй зөвлөлдөж, өөрийнх нь бий болгосон бүтцийг ашиглаж явуулсан. Мөн Заамар суманд адилхан, бид аль болохоор тэнд байгаа бүтцийг ашиглан, тэднээр юм хийлгээ гэсэн санаа орсон гэдгийг хэлмээр байна.

н.Мягмаржав: Мэдээлэл харилцааны төслийн орон нутагт хэрэгжүүлэхэд орон тоо шинээр бий болгоогүй гэж хэлж болно. Сумын иргэдийн хурал, багийн иргэдийн нийтийн хурал манай ажилтнууд очиж оролцон, мэдээлэл тараасан. Шинээр зохион байгуулсан ажил нь сумын өдөрлөг байсан. Малчдын хурал, арга хэмжээ болоход л би очиж байсан. Дэд зөвлөл шинээр байгуулсан. Сумдад дэд зөвлөл байгуулагдаад ажиллагаатай, ажиллагаагүй байгаа. Энэ яагаад ажиллахгүй байгаа гэдэг дээр маш шалтгаан байгаа. Энэ бол уул уурхай асуудлыг тойрсон мэдээллийн ил тод байдлаас хамаарахгүйгээр бий болж байгаа олон улсын зах зээлийн үнэ, уул уурхайн компаниудын иргэдтэй харьцаж байгаа харилцаа, сумын ЗДТГ-ын иргэдтэй харьцаж байгаа харилцаа, иргэд орон нутгаа сонсохгүй байгаа, төсөв санхүү гэх мэт олон асуудлууд байдаг. Одоогоор дэд зөвлөл тогтвортой ажиллахгүй байгаагаас сум бүхэнд иргэд хохироод байгаа. Иймд мэдээллийн урсгал байхгүй байна гэдгийг бид ажиллах хугацаандаа тогтоосон. Жишээлбэл, Дэлгэрэх суманд ард иргэд гэрээ байгуулах байтугай лиценз яаж хэрхэн олгогддог гэдгийг мэдэхгүй байгаа. Лицензийг Улаанбаатарт олгодог, бид оролцохгүй байна, нэг багийн нутаг дэвсгэрт бүхэлд нь лиценз олгосон байна гэх мэт асуудал байсан. Мөн сумын удирдлагууд иргэддээ мэдээлэл өгөхгүй, ярилцахгүйгээр шийдвэр гаргаж байгаа зэрэгт иргэд бухимдаад байна. Ерөнхийдөө цаашдаа дэд зөвлөл ажиллана гэдэгт итгэлтэй байна. Жишээлбэл, Оюутолгой компанийн олон талт зөвлөл маш үр өгөөжтэй ажиллаж байгаа. Энэ бүтэц нь сумын иргэдийг хүчтэй, мэдлэгтэй болгодог юм байна, уул уурхайн талаар ойлголттой болгодог байна. Тэд иргэдтэйгээ хамтраад төлөвлөдөг, бууруулдаг болсон байна. Сум компаниас наадам зохион байгуулах зэрэг хандив тусламж гуйж байна. Сум компаниатай гэрээ байгуулчихвал иймэрхүү асуудал үгүй болно. Дэд зөвлөл ажиллахгүй байгаа шалтгаан нь санхүүгийн асуудал юм. Угаасаа дараа жилээс улсын төсвөөс мөнгө гарахаар байна гэхдээ энэ зардал хүрэлцэхгүй юм. Тийм учраас бид сумын зөвлөлийн үйл ажиллагааг тогтвортой явуулахад 6 сая төгрөг шаардлагатай гэсэн тооцоог гаргасан.

А.Михайлова: Одоо суманд байгаа бүтцийг аль болохоор ашиглахыг зорьсон. Суманд мэдээллийн ажилтан ажиллаж байгаа. Тодорхой хугацаанд мэдээллийн ажилтан маань үйл ажиллагаа явуулаад байвал үр дүнтэй гэж харж байгаа. Одоо ч гэсэн орон нутагт дэд зөвлөлийн нарийн бичгийн даргаар ч юм уу ажиллаад явж байгаа. Дараа жилээс улсын төсөв эсвэл уул уурхайн компанитай хийсэн гэрээн дээр тулгуурлан бусад үүсвэрээс санхүүжилтээ тусгаад явбал тогтвортой ажиллах боломжтой гэж харж байгаа. богино хугацаандаа мэдээллийн ажилтан гэж явж байгаад цаашдаа орон нутгийн хэрэгцээнд тааруулаад ажиллах боломжтой.

Б.Батболд: Анх эдгээр сумдыг сонгохдоо хамгийн хүнд асуудалтай газар хаана байна, ямар асуудал тулгамдаж байна зэргийг судалж байгаад сонгосон байх. Танилцуулгаас харахад хамгийн шинэ, маш олон уул уурхайн төслүүд хэрэгждэггүй Дэлгэрэх суман дээрээ хамгийн муу ажилласан харагдаж байна. яагаад гэхээр малын хорио цээрийн талаар ярьлаа. Төсөл нэг жил хэрэгжлсэн, хорио цээр бас нэг жил болсон болж харагдах гээд байна. Заамар суманд маш олон төсөл хэрэгждэг, мэдээлэл ихтэй хамтарч ажиллаад сурчихсан байх. Сум бүрт төсөв байгаа байх, Дэлгэрэх суманд нилээд мөнгө хэмнэгдсэн юм шиг байна. Энэ талаар асуумаар байна.

н.Мягмаржав: Энэ төсөл маань мэдээлэл харилцааны төсөл байсан. Төсөл хэрэгжих үеэр малын гоц халдварт өвчин гарсны улмаас хорио цээр тогтоосон ба ямар нэгэн олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахыг хориглосон байсан. Хорио цээр саяхан 1 сард тавигдсан. Ингээд бид мэдээллийн төвөө нээсэн, ажилтанаа ажиллуулсан, олон нийтийн сүлжээ ашиглаж мэдээлэл түгээсэн мөн брошур тараасан. Дараагийн шалтгаан нь Дэлгэрэх суманд 2 нам хувааж засаг барьдаг. Хурлын дарга нь Ардчилсан нам, Засаг дарга нь ардын намын хүн байсан. Байгаль орчны байцаагч гэхэд 3 дахь удаагаа солигдсан байсан. Уул уурхайн талаар ямар ч ойлголтгүй, иргэд нь ямар ч мэдээлэлгүй. Угаасаа мал аж ахуйн сум, уул уурхайг ажиллуулах сонирхол багатай байсан. Ийм газар ОУИТБС-ын талаар ярихад үр дүн муу байсан зэргээс шалтгаалан бид энэ суманд муу ажилласан.

Б.Энх-Амгалан: За баярлалаа, асуулт асууж, санал хэлсэн хүмүүстээ баярлалаа. Бид цагаа барих хэрэгтэй, тэгэхээр одоо саналаа хураая. Цаашдаа энэ төслийн үргэлжлүүлэх үү, үгүй юу гэдэг дээр санал хураая. Энэ төслийг дэмжээд үргэлжлүүлэхээр бол ЕСБХБ-наас дараагийн санхүүжилтийг гаргаад 2-3 жилийн хугацаатай хэрэгжих боломжтой юм байна. За одоо саналаа хураая.

А.Михайлова: Энэ бол зөвхөн тайлангийн төсөл юм, үүн дээр гишүүдийн өгсөн саналыг тусгаад ЕСБХБ болон ажлын албанд хүргүүлнэ.

Б.Энх-Амгалан: Саналаа хэлэх хүмүүс 2 минутанд багтаагаад саналаа хэлчих, дараа нь санал хураая.

Б.Дэлгэржаргал: Төслийн танилцуулгыг сонслоо, цаашид дэмжээд үргэлжлүүлэх боломжтой гэж үзэж байна. Орон нутагт мэдээлэл байхгүй учраас гол асуудал үүсэж байгаа. Тиймээс энэ төслийг мэдээллийн суурь болгож аваад цаашдаа аймаг бүрт төлөөлөлтэй болгох зүйтэй учраас энэ төслийг дэмжих нь зүйтэй гэж харж байна. ЕСБХБ үүнийг цааш нь санхүүгээр дэмжиж ажиллах боломжтой юу гэсэн санал байна.

О.Отгонсайхан: Энэ төслийг дэмжих нь зүйтэй гэж бодож байна. Орон нутагт мэдээлэл дутуу учраас иргэд бухимддаг. Мэдээллийг төслөөр дамжуулан иргэдэд мэдээллийг ойлгуулах боломжтой болох юм, дэмжих саналтай байна.

Б.Баярмаа: Энэ төсөлд иргэний нийгмийн талаас оролцож байсан. Төсөл хэрэгжих хугацаанд дэд зөвлөлийн үйл ажиллагаа идэвхсэн. Орон нутгийн удирдлагууд хичнээн уул уурхай ажиллаж байна зэргийг бүрэн хянаж чадахгүй байгаа, төсөв мөнгө ч байхгүй. Иймээс нэгэнт Засгийн газрын тогтоолын дагуу дэд зөвлөлийг байгуулаад, хэдэн

хүн ажиллаад, энэ асуудлын талаар яваад байх боломжтой юм гэдэг нь харагдсан. Төслийг эхлэхэд ч бид ярьж байсан. Төслийн хүрээнд тэдэн төгрөгийн хандив тусламж өгсөн гэдэг суртчилгаанаас илүүтэйгээр төсөл дуусахад энэ талаарх ажилтныг чадавхжуулаад цааш нь үргэлжлүүлэн аваад явах боломжтой юм бна гэж харсан. Энэ чиглэлээр явуулах гэж оролдсон, цаашдаа ч тэнд байгаа хүмүүсийг чадавхжуулаад хөгжүүлчихвэл цаашдаа тогтвортой ажиллуулах боломжтой болно. Одоо улсын төсвөөс тодорхой хэмжээний төсөв мөнгө яригдаж байна, арга барилаа олоод, ажиллаад сурчихсан хүмүүсийг ажиллуулаад, үйл ажиллагааг тогтвортой болгох боломжтой. Иргэдийн маргааныг шийдвэрлэх маш хэцүү, хэрүүл маргаан гарна. Орон нутгийн хэрэгцээ гэж яг юуг хэлээд байна, үүнийг тодорхой болгох хэрэгтэй. Иргэдийнх үү, төрийнхүү эсвэл компанийнх уу гэдгийн тодорхой болгоорой. Цаашдаа хэрэгцээ шаардлагыг сайн судалж байж хэдэн суманд хэрэгжүүлэхийг тогтоох нь зүйтэй байх, тооны хойноос хөөцөлдөх нь дэмий байхаа, ингээд төслийг цааш үргэлжлүүлэх саналтай байна.

Н.Баярсайхан: Төслийн хувьд бид анхнаасаа төслийн баримт бичгийг үзье гэдэг санал тавьсан, үзэж чадаагүй. Төслийн баримт бичгийг зөвхөн Адам смит байгууллага, ЕСБХБанк л мэдэж байгаа. Ямар хэрэгцээ дээр ямар зорилгоор ажилласан талаар мэдээгүй байгаа. Цаашдаа төслийн баримт бичгийг нээлттэй болгох ёстой. Үүнийг шийдвэрийн төсөлд тусгах хэрэгтэй. ЕСБХБ өөрөө төслөө бичээд Адам смит байгууллагыг сонгоод ирсэн. Адам смит өөрсдөө хөдөөгүүр нэг ч яваагүй. Цаашид гүйцэтгэгчийг сонгоход бид оролцдог байхад анхаарах ёстой. Дундаас нь зөвлөх байгууллага орж ирснээр хүрэх үр дүнд нөлөөлсөн гэж үзэж байна. Тухайлбал, жишиг 5 суманд компьютер авч өгнө гэсэн, нэг нь ч аваагүй байна. Ер нь ажлын алба, ажлын хэсгийнхэн 2012 оноос хойш хөдөө аймаг сумаар маш олон сургалтыг хийсэн ч үр дүн гарахгүй байсан. Энэ төсөл хэрэгжиж эхэлснээр дэд зөвлөл маш идэвхтэй ажиллаж эхэлсэн. Гурвантэс суманд гэхэд гэрээ байгуулсан бүхэн муухай харагддаг байсан харин дэд зөвлөлийг ажиллуулаад гэрээ байгуулаад ажилласнаар компани иргэн 2 ойртож, ойлголцож эхэлсэн, дэд зөвлөл сайн ажилласан, Ерөнхий сайдын нэрэмжит шагналыг ч авсан байгаа. Тэгэхээр бидэнд хэрэгцээ байгаа учраас цаашид үргэлжлүүлэх шаардлагатай, яаж хэрэгжүүлэх вэ гэдэг дээр тохирох ёстой. Улсын төсвөөс 188 сая төгрөг гаргавал энэ төслийг хэрэгжүүлэх талаар эргэж харах талаар ярьж байна. Бид энэ төслийг хэрэгжүүлэхээр 5-10 сумдын асуудлыг шийдвэрлэх боломжтой харин тогтвортой улсын төсвөөс мөнгө гаргах асуудлаа шийдэж чадвал 330 сум, 21 аймгийн асуудлаа шийдэж чадах юм, хүрээний хувьд ийм ялгаатай гэж үзэж байна. Хурлаас гарсан саналуудыг тусгаад шийдвэрээ илүү бодитой гаргах нь зүйтэй байх.

Г.Түвдэндорж: Танилцуулгаас харахад компаниудын үйл ажиллагааны талаарх мэдээллийг зөв талаас нь өгөх нь компани иргэдийн харилцаанд чухал зэрэг нөлөөтэй гэдгийг ойлгож байна. Уул уурхайн талаар зөв ойлголт өгөх, уул уурхай нь ямар ач холбогдолтой, ямар үр өгөөж өгдөг талаар иргэд ойлгодоггүй, ойлгохыг ч хүсдэггүй. Харин энэ талаарх мэдээллийг үнэн зөв өгөөд явж байгаа нь харагдаж байна, иймээс энэ төслийг аль болохоор дэмжээд аль болох өргөн хүрээнд улам өргөжүүлж, Засгийн газрын зүгээс ард иргэдэд зөв ойлголт өгч явах нь чухал байгаа. Энэ нь зөв ойлголт, мэдээлэлтэй холбоотой байдаг. Энэхүү төслийг хэрэгжүүлэхээр ЕСБХБ сайн тусалж ажиллаж байна, энэ нь тусламжийн бас нэгэн хэлбэр иймээс үүнийг дэмжээд явах нь зөв байхаа, баярлалаа

Э.Энхбат: Төслийн маань зорилго нь орон нутагт үйл ажиллагаа явуулж буй бүх талуудыг хариуцлагатай болгох юм. Орон нутагт иргэд, нутгийн өөрөө удирдах байгууллага, ЗДТГазрын хоорондын мэдээллийг солилцуулах хэрэгтэй байна, энэ маш чухал. Жишээлбэл, Заамарын наадам Монгол улсад байхгүй том байтай болдог, үүнийг манай алтны хэдэн компаниуд л гаргадаг, иргэд нь мэддэггүй. Тухайн орон нутагт өгч байгаа хөрөнгө оруулалтыг хэрхэн зарцуулж байгаа талаарх мэдээллээ иргэдэд тодорхой гаргаж өгдөггүй. Энэ төслийн тодорхой зорилго нь ийшээ чиглэсэн байгаасай гэж хүсэж байна. Аж ахуйн нэгж байгууллагууд өөрсдийн мэдээллээ аль болохоор танилцуулдаг.

Цаашдаа энэ төслийн үйл ажиллагааг төгөлдөржүүлээд явах байх гэж бодож байна, баярлалаа.

Б.Энх-Амгалан: За баярлалаа, эсрэг саналтай хүн байна уу? Төслийг цаашдаа үргэлжлүүлэхийг дэмжиж байгаа талаар санал хураая.

Гишүүдийн 100 хувийн дэмжлэгтэйгээр төслийг цаашид үргэлжлүүлэхийг дэмжив.

Б.Энх-Амгалан: Шийдвэрийн төсөлд найруулгын хувьд тодотгол оруулах, гишүүд саналаа онлайнаар өгөөд, саналыг шийдвэрт тусган эргээд хариу өгөхөөр хурлын тэмдэглэлд тусгая.

### **ХЭЛЭЛЦСЭН нь: ОУИТБС-ын дэд зөвлөлийн зардлын санхүүжилтын төлөвлөлт, тооцооны тухай**

Б.Дэлгэрмаа: Дэд зөвлөлийг ажиллуулах тогтоол 2012 онд гарсан. Засгийн газрын 222-р тогтоолын 13.2, 13.3-т Үндэсний зөвлөл нь тайланг аймаг, сумдад сурталчилах, үр дүнг нийтэд мэдээлэх, аймаг, нийслэлийн ЗДТГ-аас зохион байгуулж буй ажлын явц, үр дүнг хэлэлцэн тодорхой чиглэл, үүрэг даалгавар өгч ажиллах гэсэн үүргийг хүлээсэн байгаа. Дэд зөвлөлийн үйл ажиллагаатай танилцаад гэрээний ил тод байдал, гомдол гаргах механизмыг уялдуулах уу гэдгийг шийдвэрлэх хэрэгтэй.

Дэд зөвлөл нь 5 чиг үүрэгтэй. Үүнд, жил бүр ОУИТБС-ын тайланг илгээх, ОУИТБС-ын тайланг олон нийтэд мэдээлэх үүрэг бүхий дэд зөвлөл байгуулах, хяналт тавих, БО-той холбоотой мэдээллийг хэлэлцэх, нийтэд мэдээлэх, гэрээ, түүний хэрэгжилтийг нийтэд мэдээлэх, сумдад дэд зөвлөл байгуулах үүрэгтэй байдаг. Ийм дэд зөвлөлийг ажиллуулах гээд 5 жил болж байна шинээр 263 дугаар тогтоолыг өнгөрсөн жил гаргасан. Үүнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын үүргийг тодорхой болгосон мөн Сангийн сайд болон аймаг, нийслэлийн засаг дарга нарт ОУИТБС-ын дэд зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг 2019 оноос эхлэн улсын болон орон нутгийн төсөв тусган санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгосон. Бид 2012 онд тогтоол гарснаас хойш 2013 оноос чадавхи бэхжүүлэх үйл ажиллагаа нилээд идэвхжсэн. 2013 онд бүх аймгийг хамарсан бүсийн чуулган, 2014 онд 8 сумын өдөрлөг, 2015 онд бүсийн 2 дугаар чуулган, 3 сумын өдөрлөг хийсэн. 2016 онд санхүүжилт хүндрэлтэй байсан, 14 аймгийн засаг даргын орлогч, нарийн бичгийн даргатай нь Улаанбаатарт сургалт хийсэн. 2017 онд саяны 5 суманд төвлөрч ажилласан. Бид тогтвортойгоор дэд зөвлөлийн үйл ажиллагааг орон нутагт хүргэхээр ажиллаж байна. Энэ хүрээнд 21 аймаг, нийлэл дэд зөвлөлөө байгуулсан. 2016,2017 оноос хойш дэд зөвлөлүүд төлөвлөгөөгөө гаргаж ирүүлж байгаа, зарим нь төлөвлөгөөгүй байгаа. Бид дэд зөвлөлийн хийх ажлыг гурван багцад хувааж байгаа. Үүнд, тайлан илгээх, суртчилах, чадавхи бэхжүүлэх, хамтын ажиллагааны ажлыг хийхээр тусгасан. Бид улсын төсвийн зардлаар санхүүжүүлэх учраас хязгаарлагдмал, бага зардлаар хийхээр тусгасан. Үүнд, өдөрлөг чуулган зохион байгуулах, сумдын үйл ажиллагаатай танилцах, мэдээлэл суртчилгаа, бичиг хэрэг, дэд зөвлөлийн нарийн бичгийн урамшуулал гэсэн зардлуудыг тусгасан. Ингээд нийт дэд зөвлөлийн санхүүжилтийг 188 сая төгрөгийн төсөв оруулах саналтай байна /танилцуулгыг хавсаргав/

Б..Энх-Амгалан: За баярлалаа.

Н.Баярсайхан: Дэд зөвлөлийн санхүүжилтийн хэмжээг тогтоохдоо зарчмын хувьд нэг асуудлын тохирох хэрэгтэй байна. Уул уурхайг иргэдэд ойлгуулах, уул уурхайн орлогын тодорхой хувийг дэд зөвлөлийг санхүүжүүлэх зарчмаар зохицуулах нь зөв байна. Энэ тухай удаа дараа хэлж байсан. Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгөөр уул уурхайтай сум, уул уурхайгүй сумын хөгжлийн ялгааг арилгах, уул уурхайн өгөөжийн нэмэгдүүлэх, иргэдэд хүргэх үүднээс ийм зохицуулалтыг хийсэн байдаг. Тэгэхээр орон нутгийн хөгжлийн сангийн мөнгө сум бүхэнд орж байгаа. Үүний 1 хувийг юм уу хуваарилахад жилдээ 6,5-7,5 сая төгрөгийн санхүүжилт авах боломжтой. Санхүүжилтийг ингэж шийдвэл зарчмын хувьд ч зөв, уул уурхайн орлогоор иргэдэд мэдээлэл хүргэхэд

чухал бөгөөд энэ мөнгө нь тогтмол, тогтвортой байх боломжтой юм. Санхүүжилтийг гүйцэтгэлээр нь олгодог байя, юу ч хийхгүй байгаа зөвлөлд автоматаар мөнгө өгөөд яах вэ. Зардлын задаргаанаас харахад эхний 2 ажил нь төрийн байгууллагын хийх ёстой ажил, дараагийн ажлууд нь хамтын ажиллагаан дээрээ тусгаад хийгээд явах боломжтой ажил юм. Эдгээр ажлыг хийхэд 3 сая төгрөг хаанаа ч хүрэхгүй, мөн л компаниас хандив авдаг нь хэвээрээ байна. Тэгэхээр хамгийн багадаа 7,5 сая төгрөг байвал сумын иргэдэд зориулаад уул уурхайн талаарх мэдээлэлтэй сонин гаргах боломжтой. Одоо Дундговь аймгийн Өлзийт, Өмнөговь аймгийн Гурвантэс сумын зөвлөлүүд тогтмол ажиллаж байгаа. Гурвантэс суманд компаниуд маш их мөнгө гарган бүтээн байгуулалт хийж байна. Одоо айлууд руу халуун хүйтэн ус татах гэж байна, суманд хатуу хучилттай зам тавих гэж байна. Үүнийг уул уурхайн өгөөж гэж харахгүй байна, компани өөрийгөө суртчилахгүй байна, орон нутгийн захиргаа ч мэдээлэл өгдөггүй юм байна. Иймээс иргэдэд мэдээлэл өгөхийн тулд дээрх ажлуудаар дамжуулж өгнө. Тиймээс зарчмын хувьд тогтвортой санхүүжилтээ харвал орон нутгийн хөгжлийн сангийн мөнгөний 1 хувь байхаар оруулах, гүйцэтгэлээр нь өгдөг байх нь хамгийн оновчтой шийдэл болно.

Б.Энх-Амгалан: За баярлалаа. Баярсайханы санал горимын хувьд зөв санал байна гэхдээ үүний тулд хууль гарах ёстой. Тэгэхээр хол байна. Тэр байтугай дэд зөвлөлийг санхүүжүүлэх 188 сая төгрөг ч хүнд байгаа. Ингээд хөгжлийн сангийн 1 хувь гэж тогтох уу, 188 сая төгрөг гэдэг дээрээ тогтоод дээш нь өргөн мэдүүлэх үү гэдгээ тогтох хэрэгтэй байна.

Н.Баярсайхан: Ер нь ажлын хэсгийн гишүүд байгаа дээр хандив гэдэг ойлголт байх уу гэдгийг тогтмоор байна. Дэд зөвлөлийн санхүүжилтийг хандиваар авах, орон нутаг хандив авах зэрэг ойлголтууд байгаад байна. Хандивын цаана далд хандив гэж байна. Энэ дээр нэг ойлголттой болохгүй бол олон асуудал дээр гацаа үүсэж байгаа.

Ж.Батцэнгэл: Хэрвээ 1 хувь гээд оруулчихвал хандив тусламж гэдгээ болих хэрэгтэй, аль ч хуулин дээр хандив тусламж авч болно гэж байдаг. Энэ санаагаа суулгавал, хандив авч болохгүй гэдгээ зааж өгөхгүй бол болохгүй байх. Бид төслийн ажлаар Ерөө явж байсан, хандив тусламжийн мэдээгээ өг гэхээр уул уурхайн хүмүүс нь өгдөггүй зэрэг хүндрэлтэй юм байсан.

Б.Баярмаа: Энэ нь социализмын төсөв гэдэг шиг хавтгайрсан байна. Сум аймаг бүрт өөр өөр ажиллагаатай байгаа. Зарим суманд ажил явуулахад хүндрэлтэй байгаа, зарим нь дэд зөвлөл байгуулсан төдий ажилладаггүй ч байгаа. Үүнийгээ илүү бодитой буулгаад, дэд зөвлөлүүдийн төлөвлөгөөнд үндэслээд яг ямар ажил хийхээр төлөвлөсөн байна, түүнд үндэслэн хиймээр байна. Энэ 3-5 сая төгрөг дэд зөвлөлийг ажиллахад хаанаа ч хүрэхгүй, 5 сая төгрөгөөр зөвхөн нэг аймгийн уулзалт л хийж байгаа. Тэгэхээр өөр эх үүсвэр боломжууд юу байна гэдгийг судлах ажил хиймээр байна. Хуулийн боломжууд нь юу байна, болохгүй бол тэр хуульд нь нэмэлт өөрчлөлт хийх мэтээр зохицуулчих боломж байдаг. Тухайлбал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль дээр торгуулийн мөнгөнөөс энэ ажиллагааг санхүүжүүлэх, сургалт суртчилгаа хий боломжтой гэж заасан байдаг. Хамгийн их гарч байгаа гэмт хэрэг нь байгаль орчны гэмт хэрэг байдаг үүнийг Сангийн яам хууль дээр нь зохицуулах боломж байгаа. Энэ ажлыг хийх боломж бий болгоход хүрэлцэх төсвийг зохицуулахын тулд ажлын хэсэг гаргаад судлах санал байна.

Б.Дэлгэрмаа: Тэгвэл 22 аймгийн яг аль дээр нь дэд зөвлөлөө ажиллуулах талаар ярилцах хэрэгтэй байх. Жишээ нь, Дундговь аймгийн 4 сумаас алийг нь оруулах вэ?

Б.Энх-Амгалан: Санхүүжилтийн хэмжээ тоондоо биш юм. Их хурал дээр очоод яригдана, бодитой гаргалгаа байх хэрэгтэй. Батлагдахаа хүрвэл хэд ч байсан батлагдана.

Ч.Цогтбаатар: Ер нь сум орон нутгийг хөгжүүлэх зорилгоор тусгай зөвшөөрлийн болон уул уурхайн орлогын тодорхой хувийг суманд хуваарилахаар төсвийн хуульд

зохицуулалт хийсэн. Одоо энэ нь үйлчлэхгүй, царцаасан байгаа. Тиймээс шууд 1 хувь гэж оруулах нь эрсдэлтэй байх, хэзээнээс эргэж үйлчлэхийг мэдэхгүй. Ер нь аймгууд харилцан адилгүй байдаг иймээс ажлын цар хүрээнээс хамааруулаад төсөв нь өөр өөр гарах байх.

Н.Баярсайхан. АМНАТ-ийн 5 хувийг орон нутгийн хөгжлийн санд өгч байгаа

Ч.Цогтбаатар: Одоо өгөхгүй байгаа, 2020 оны 1 сарын 1 хүртэл царцаасан.

Б.Энх-Амгалан: Тэгэхээр одоо шийдвэрээ гаргая, бүр мөнгөгүй ч болж болно. Үүнийг бид шийдэхгүй, харин батлагдвал аймаг сум хоорондоо шилжүүлэх эрхийг эндээ үлдээе.

Б.Батболд: Зарим Их хурлын гишүүд нь тэдийг нь манай аймаг авна гэх асуудал гарч магадгүй.

Ш.Цолмон: Хөгжлийн сангийн хөрөнгөөс 1 хувь гэдэг нь болохгүй юм байна. Учир нь уул уурхайтай сум нь хөгжөөд, уул уурхайгүй сум нь хөгжихгүй байх том ялгаа, асуудал гарах байх. Хандивыг Төсвийн тухай хуулиар зохицуулсан байдаг. Бид ЗГХЭГ-ын зөвлөмжийн дагуу хэрвээ дэд зөвлөл байгуулагдсан байгаа бол санхүүжилтийг олгох нь зүйтэй гэсэн чиглэлийн дагуу төсвийг хийсэн, хуулиараа 4 сарын 15-ны дотор танилцуулах ёстой, одоо хугацаа болсон байна. Одоо ЗГХЭГ-т оруулсан, Сангийн яам руу арай яваагүй байгаа юм байна.

Г.Түвдэндорж: Бодитой төсөв хийгээд оруулах нь зүйтэй байна, батлагдах эсэхийг хэлж мэдэхгүй байна.

Б.Энх-Амгалан: Энэ 188 сая төгрөгөө нэмэгдүүлээд, дэд зөвлөлийн нарийн бичгийн даргын урамшуулал гэх мэт зардлыг хасаж оруулах нь зүйтэй. Төрийн албан хаагч угаасаа ажлаа л хийж байгаа. Ард иргэдэд мэдээлэл түгээх, хүнд хүрсэн соён гэгээрүүлэх ажил хийхэд ядаж л бинзений мөнгө, хоол томилолтын зардал гэх мэт бодитой үндэслэлтэй зардлыг оруулах нь зөв байна. Төсвийн задаргааг ухаалаг болгоод үнийн дүнг 288 сая төгрөг болгоод, ЗГХЭГ-т хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

**ХЭЛЭЛЦСЭН нь: Эрдэс баялагийн салбарт үйлчилж буй хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах тухай.**

Ч.Цогтбаатар: Өнөөдрийн танилцуулгыг Зууннаст хийх ёстой байсан, хуралтай байгаа тул би танилцуулж байна. Эрдэс баялагийн хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай багц хуулийн төслийн тухай танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5.2.3 дахь заалтад “Эдийн засаг, бизнес, худалдаа, өмч, санхүүгийн эрх зүйн үндсийг боловсронгуй болгож, өмчлөх эрхийн баталгааг алдагдуулсан хууль тогтоомж, шийдвэрийг засч сайжруулах” зорилт тусгагдсан. Мөн Уул уурхайн салбарын хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор ажлын хэсэг байгуулах тухай А/67 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулсан. Энэ ажлыг ГХАН-ийн санхүүжилтээр ажлын хэсэг гаргаад, энэ чиглэлээр мэргэшсэн хуульчдыг оролцуулан хийлгэсэн байдаг. Энэ ажлын хүрээнд уул уурхайн салбарт мөрдөж байгаа 10 гаруй хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар судалсан. Судалгааны дүнгээр нийт 267 давхардал, 150 хийдэл, 150 зөрчил байна гэж гаргасан, тайланд дүгнэлт баримтууд тусгагдсан байгаа. Ялангуяа Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль нь бусад хуультайгаа 212 давхардалтай, 11 хийдэл, 17 зөрчилтэй байна гэсэн дүгнэлт гарсан. Түүнээс гадна Газрын хэвлийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хуулинд томоохон зөрчлүүд байна гэдгийг гаргасан. Эдгээр давхардал хийдлийг арилгахын тулд хуулийн үзэл баримтлалыг боловсруулсан. Ер нь хууль гаргахад тус бүрт нь хуулийн үзэл баримтлал боловсруулдаг, энэ хууль нь багц учраас нэг үзэл баримтлалаар явах юм байна. Энэхүү хуулийн үзэл баримтлалыг 2 сайдын тушаалаар баталсан, үүний дагуу

өөрчлөлтийг хуулиудад оруулсан байгаа. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль нь Ашигт малтмалын тухай хуультайгаа 90 орчим хувийн давхардалттай байна. 11 зүйл заалт нь хийдэлтэй, 17 зүйл заалт нь зөрчилтэй гэж дүгнэсэн. Иймээс энэ хуулийг хүчингүй болгох боломжтой гэсэн чиг гарсан. Мөн ил далд уурхайн талаар нэр томъёо, зохицуулалт ямар ч хуулинд байхгүй байсныг хуульчилж өгөхөөр болсон. Энэ оны 1 сарын 1-нээс эхлэн тусгай зөвшөөрлийг зөвхөн сонгон шалгаруулалтаар олгодог болсон. Ашигт малтмалын тухай хуульд 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийг зөвхөн сонгон шалгаруулалтын журмаар олгодог болсныг өөрчилж, хуучин зохицуулалтаар буюу өргөдлийн болон сонгон шалгаруулалтын журмаар тусгай зөвшөөрөл олгодог байхаар нэмэлт, өөрчлөлт оруулсан. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Ашигт малтмалын тухай хууль болон Цөмийн энергийн тухай хуульд цацраг идэвхт ашигт малтмалын нөөц ашигласны нэмэлт төлбөрийн тухай зохицуулалтыг оруулаагүй, орхигдуулсныг хуульчлах, Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан нутгийн захиргааны байгууллагатай байгуулах гэрээг байгуулах этгээдийг хуульд тодорхой тусгаагүйг нэмэлтээр тодорхой байдлаар оруулах, Олборлосон түүхий эд, баяжмал, бүтээгдэхүүнээ ашигт малтмалын гаралтай түүхий эд, баяжмал боловсруулах, ашигт малтмалын эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлдэг дотоодын аж ахуй эрхлэгчдэд шаардагдах хэрэгцээг буюу дотоодын зах зээлийн хэрэгцээг хангаж, олон улсын зах зээлийн үнээр худалдсаны дараа экспортлох талаар зохицуулалтын оруулсан. Энэ ажлын хүрээнд Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, Газрын тосны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий гарын хамгааллатын бүс, ойн сан бүхий гаарт ашигт малтмал хийх хориглох тухай тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийн боловсруулж байна. Хуулийн давхардал хийдэл арилсны дараа ямар үр дагавар гарах вэ гэвэл, хөрөнгө оруулагчдын итгэлцэл бэхжиж, хөрөнгө оруулалт нэмэгдэнэ, хуулийн давхардал арилахын зэрэгцээ өмнө нь эрх зүйн хийдэл тодорхой бус зохицуулалтаас үүсч байгаа хүндрэлтэй асуудлууд цэгцлэгдэнэ, олон удаа хуульд нэмэлт өөрчлөлт оруулдаг байдал багасна, төрийн холбогдох байгууллага, олон нийтийн байгууллага, иргэдийн оролцоо хангагдаж, үүрэг хариуцлага тодорхой болно, хуулийн зарим ойлголт, нэр томъёо тодорхой болно гэж хаж байгаа. Энэхүү багц хуулийн төсөл нь Монгол улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хуультай нийцсэн бөгөөд улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, газрын тухай хууль зэрэг 10-аад хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулна. Энэ өөрчлөлт нь ноцтой өөрчлөлт биш, зарчмын шинж чанартай шинэ юм оруулахгүй байхаар Хууль зүй, дотоод хэргийн яамтай тохирсон байгаа. Энэ хуулийн төсөл дээр яамдуудаас санал авсан, Сангийн яамны санал ирвэл УИХ-д оруулахад бэлэн болоод байна. За баярлалаа.

Э.Энхбат: АМНАТ-ын 2,5 хувийг хуулиндаа заалт оруулж байна уу өөр ямар зохицуулалт оруулсан бэ?

Ч.Цогтбаатар: 2019 оны 1 сарын 1 хүртэл 2,5 хувь байна, цаашаа хуулиараа зохицуулна гэсэн хуулийн зохицуулалт байгаа. Энэ чиглэлээр Татварын багц хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл зэрэг явж байгаа. Сангийн яам шийдэх байх.

Б.Дэлгэржаргал: Сангийн яаманд санал явсан, 5 жилээр сунгах санал хүргүүлсэн.

Э.Энхбат: Баярлалаа, Урт нэртэй хуульд талбайн хэмжээний талаарх хийдэл гарсан байдаг, энэ хуулиар зохицуулагдаж байгаа юу?

Ч.Цогтбаатар: Энэ чиглэлээр өөрчлөлт оруулаагүй. Ер нь Байгаль орчны яаманд ирсэн саналуудыг үндэслэн боловсруулсан, зөвхөн давс шүүтэй холбоотой заалтад зохицуулалт орсон.

Э.Энхбат: Аж ахуйн нэгжүүдийн хэлэлцүүлэг хэзээ болох вэ?

Ч.Цогтбаатар: Хэлэлцүүлэг болсон, Дэлгэржаргал дарга байсан байх. Ер нь бол хуулиудын давхардалтай холбоотой өөрчлөлтүүд орж байгаа, зарчмын шинэ юм байхгүй.

Л.Төр-Од: Хууль хоорондын давхардал, зөрчил, хийдлийг арилгаж байгаа нь сайшаалтай. Энэхүү өөрчлөлт нь нийгэм талдаа ямар үр дагавар үүсэх вэ, танилцуулга дээр эдийн засгийн талаас нь илүү оруулсан байна. Нийгэм эдийн засгийн үр дагаварын талаар нарийвчилсан тандалтын судалгаа, хэлэлцүүлэг хийсэн үү? Хууль зүйн хүрээлэнтэй хамтарч ажилласа уу?

Ч.Цогтбаатар: Хуулийн тогтоомжийн дагуу шинэ хууль гаргахад нилээд олон судалгаа хийдэг, хуулийн хэрэгцээ шаардлагын тандалт судалгаа, хуулиас гарах үр дагаврын судалгаа, зардлын судалгаа хийх ёстой. Энэ нь багц хуулийн тухайд хийх шаардлага байдаггүй юм байна, иймээс дээрх судалгаанууд хийгдээгүй. Шууд яамдаас санал аваад Засгийн газраар хэлэлцүүлээд, Улсын их хуралд өргөн барихаар байгаа. Харин нийтийн хэлэлцүүлгийг 1 удаа зохион байгуулсан.

Л.Төр-Од: Нийтийн сонсгол зохион байгуулсан уу?

Ч.Цогтбаатар: Тийм юм байхгүй.

Б.Энх-Амгалан: Энэ хуулийн нэмэлт өөрчлөлт нь хэлэлцүүлэг хийгээд санал авах шатандаа явж байгаа юм байна. Бид ерөнхий мэдээлэл сонслоо, хэрвээ санал өгөхөөр бол өөрсдөө Уул уурхайн яаманд гаргаж болно эсвэл саналаа нэгтгээд ЗГХЭГ-аар дамжуулан хүргүүлэх 2 арга байна. Цаг хэмнэх үүднээс асуудлыг нээлттэй үлдээгээд, саналаа өгөх боломжтой гэж үзээд дараагийн асуудалдаа орох санал байна. Шийдвэрийг төслийн дагуу гаргаж байна.

#### **ХЭЛЭЛЦСЭН нь: ОУИТБС-ын 2018 оны баталгаажуулалтын дүнг бататгах ажлын төлөвлөгөөний төслийн тухай танилцуулга**

Ш.Цолмон: За баярлалаа, Монгол ОУИТБС-ыг хангасан 2 дахь орон болсон. Энэ тухай Ерөнхий сайдад танилцуулаад, Ерөнхий сайд хариу мэндчилгээг ОУИТБС-ын ОУ-ын нарийн бичгийн дарга нарын газарт илгээсэн байгаа. Мөн ЗГХЭГ болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны сайдад танилцуулсан. Баталгаажуулалтын дүнг баталгаажуулах ажлын хүрээнд төлөвлөгөө боловсруулаад Ажлын хэсгийн гишүүдээс санал авахаар танилцуулж байна. Энэ төлөвлөгөөнд 2018 ондоо 15 ажлыг хийхээр тусгасан гэхдээ зарим ажил нь шууд шийдэгдчих ажил биш байгаа. Ашиг хүртэгч эздийг ил тод болгох “2020 замын зураг”-ийн дагуу УУХҮЯ дээр хуулийн ажил хэсэг байгуулна. Монгол Улсын ОУИТБС-ын тайлан, Ашиг хүртэгч эздийн ил тод байдлын тухай УИХ-ын байнгын хороонд танилцуулах; МХЕГ-аас 2017 онд ОУИТБС-ын тайлангаа гаргаагүй компаниудтай хариуцлага тооцсон тухай сонсголыг ОУИТБС-ын Үндэсний зөвлөлд тайлагнах; Бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэ маягтаар байгуулсан дүнг ОУИТБС-ын Үндэсний зөвлөлд танилцуулах; ААН-үүдийг орон нутагт харъяалалтай болгох асуудлыг судалж ОУИТБС-ын Үндэсний зөвлөлд танилцуулах, Татварын орлогын тодорхой хувийг орон нутагт үлдээдэг болох судалж ОУИТБС-ын Үндэсний зөвлөлд танилцуулах; Байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцааны 2016, 2017 оны тайланг компани бүрээр нөхөж гаргах зэрэг 15 ажлын хийхээр төлөвлөсөн, ард хариуцах байгууллага хийх хугацаа, хүрэх үр дүнг оруулсан./танилцуулгыг хавсаргав/

Б.Энх-Амгалан: Манай ОУИТБС гэдэг нь зөв явбал хүчтэй шийдвэр гаргадаг механизм болгохыг зорьж байгаа. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд юм юм руу орох маягтай байдаг. Бидний зарим нь албан тушаалаараа ордог, зарим нь сонгогдон ажилладаг. Бид хэдийгээр цалин мөнгө авдаггүй ч үнэн сэтгэлээсээ жилдээ 4 удаа хуралдая гэсэн санаа байна. Тэгэхээр бидний ажил их, хуралдаан шахуу болно. Энэ төлөвлөгөөг энэ хэвээр

батлах уу, заримыг нь хасах уу? Биелэлт 100 хувь байна гэдэгт итгэлгүй байна, мөн үр дүн нь хангалттай байх уу гэдэгт эргэлзэж байна.

Ж.Батцэнгэл: Татвартай холбогдогдолтой нэг асуудал орхигдсон юм шиг байна. Серверийг холбох, мэдээлэл дамжуулах боломжтой болгох талаар оруулвал ямар вэ? Төлөвлөгөөний 8 дугаар ажил нь бараг бэлэн байгаа, энийг танилцуулснаар ямар үр дүнд хүрэх вэ, үүнийг хасах саналтай байна. Мөн 6 дугаар ажлын ТЕГ болон Сангийн яам гэж оруулаад манай 2 байгууллага хамтран хийвэл илүү үр дүнтэй байх болов уу гэсэн санал байна.

Ш.Цолмон: Ажлын үр дүнг Үндэсний зөвлөлд танилцуулах ёстой.

Ж.Батцэнгэл: Манай баазаас рашаан ус ашигласан төлбөр бөөн дүнгээр хэн төлсөн нь харагдана, зарлага тал нь харагдахгүй. Байршуулсан барьцаа хөрөнгийг нь 5 сард нь багтаагаад өгдөг болмоор байна.

Б.Энх-Амгалан: Төлөвлөгөөний 7 дахь ажил маш зөв байна. Байгаль орчны яам мэдээллээ гаргаж өгөхгүй асуудал гардаг. ЗГХЭГ-ийн дэд дарга болон УИХ-ын гишүүн Ж.Энхбаяр нар цахимжуулах санаачилга гаргасан, энэ маш зөв юм. Манайх энэ ажлаа цахимтай холбочихвол хүсээд байгаа ил тод байдал гараад ирэх юм. Хэрвээ энийг хийхээр бол би хариуцсан ч болж байна. Өөрөөр хэлбэл нэгдсэн мэдээллийн системд манай системийг холбоод хэн ч орж үзэж болохоор нээлттэй болох боломжтой. Харин тэрнийгээ яаж ашиглах талаар хүмүүсийнхээ чадавхийг сайжруулах хэрэгтэй байх. Уул уурхайг хардаад байвал энэ сайтаар ороорой гээд зургийг нь харуулаад байхаар хийвэл зүгээр гэсэн саналтай байна. Манайхан энэ төлөвлөгөөт ажлыг цөөлөх талаас нь санал оруулвал сайн байна.

О.Отгонсайхан: Уул уурхайтай холбоотой, уул уурхайг муухай харагдуулж байгаа юм нь хууль бус олборлолт хийж байгаа хүмүүс байна. Үүнийг зохицуулах арга хэмжээ авах зохицуулалтыг ямар байгууллага хийх вэ? Аж ахуйн нэгжүүд ажиллаад, татвараа төлөөд л муу хэлүүлээд байдаг, тэднийг муу харагдуулаад байгаа нь хууль бус олборлогчид юм. Тиймээс энэ дээр ажил төлөвлөөд ажилламаар байна. Тэд ардаа нэг цагдаагийн хамгаалалтад байдаг, нутгийн иргэд мэдээллээд байхад Мэргэжлийн хяналт тоохгүй байдаг тохиолдол байна.

Б.Энх-Амгалан: Цолмон даргаа, та гадныхнаас мөнгө цаас олоод нээлттэй индэр, хэлэлцүүлэг хийх арга байхгүй юу? Бид нар нинжатай тэмцэх арга хэрэгтэй байна.

Ч.Цогтбаатар: Нөхөрлөл, хоршоо бол өөр хэрэг тэд бол төрөөс хуулинд оруулах гээд чармайж байгаа асуудал. Тэд бол нөхөн сэргээлт бүх асуудлаа хариуцах ёстой гээд орон нутагтайгаа гэрээ байгуулж ажилладаг. Хэрвээ тэд нөхөн сэргээлт хийгээгүй бол дараагийн талбайг өгдөггүй, хууль дүрэмтэй зохицуулалттай. Бүртгэлгүй, хулгайгаар ажиллаж байгаа хүмүүс тусгай хамгаалалттай газар нутгийг хүртэл авсан тохиолдолууд байна. Үүн дээр манай цагдаа хуулийн байгууллага сайн ажилламаар байна, төсөв мөнгө байхгүй гэдэг шалтгаанаар ажиллахгүй байгаа.

Э.Энхбат: Нинжаг болиулчихаар тэр засаг дарга, нам дараагийн сонгуулиар гарахгүй болчих тийм юм байдаг юм шиг байна лээ.

Б.Энх-Амгалан:Тэднийг айлгадаг, болиулдаг механизм хэрэгтэй байна. Бидэнд тэгэх статус нь байхгүй, ижилхэн эрхтэй хүмүүс биендээ шаардлага тавих боломжгүй. Тэгэхээр гаднын хөрөнгө оруулалт төсөл олоод нийгмийн сүлжээгээр тэр буруу юм хийгээд байгаа хүмүүсийг ичээх, ухааруулдаг ажил хиймээр байна. Ялангуяа сошиал, хэвлэл мэдээлэлд хандах, эх орноо гэсэн сайхан сэтгэлтэй хүмүүстэй хамтран ажилламаар байна.

О.Отгонсайхан: Ганц хоёрыг нь бариад хориход л болих байх.

Б.Энх-Амгалан: Тийм төсөл биччих хүн юу байна? Хүч хэрэглэдэг байгууллага байж болохгүй, гэхдээ илрүүлдэг засдаг механизм байх хэрэгтэй байна. Энэ ажил дээр хэдэн төгрөг гаргамаар байна, ийм юм гарах уу?

Б.Батболд: Энийг хийхэд төсөв байгаа юу?

Ш.Цолмон: Төсөв юу байх вэ? бололцоогоор л явна. Хэвлэн нийтлүүлэх дээр байж болно.

Б.Батболд: Жишээлбэл, Байгаль орчны тухай хууль тогтоомжуудыг судалж Үндэсний зөвлөлд таницлуулах ажил байна. Энэ бол маш том ажил болно.

Б.Энх-Амгалан: Үүнийг цөөрүүлэе.

Б.Батболд: Төсөв байхгүй байж том ажил тавьчихаад дараа нь биелэлт дээрээ хийгээгүй гээд гарвал үзүүлэлт унана.

Л.Төр-Од: Төлөвлөгөөний 1 дэх ажлын дагуу хуулийн ажлын хэсэг байгуулна гэсэн үүний хариуцах байгууллага нь Хууль зүй дотоод хэргийн яам илүү оролцоотой байх ёстой гэж үзэж байна. Бид Украины ОҮИТСБ-ын хүмүүстэй туршлага солилцох дугуй ширээний уулзалт хийсэн. Тэдний туршлагаас харахад АТГ энэ ажил дээр оролцох шаардлагатай, өөрөөр хэлбэл улс төрийн нөлөө бүхий этгээдүүдийн хөрөнгө оруулгын мэдүүлэг дээр илүү орох байх. Зарчмын санал гэвэл, бидэнд тараасан ажлын төлөвлөгөөг хамт унших ёстой. Өөрөөр хэлбэл бид тайлангаас гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх гэж байгаа. Төлөвлөгөөтэй санал нэг байна, зарим нь зарчмын шинжтэй юм ч байна, урсгал шинжтэй ажлууд ч байна. Бид дараа дараагийн удаа ийм олон жижиг ажил хийхгүйгээр Олборлох салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг эргэж сэргээе. Тэрнийгээ УИХ-батлуулаад авчихвал дараа нь бидэнд ийм зовлон тулгахаргүй. Тайлан баталгаажуулалт ч гэсэн эргээд системтэйгээр хийх тогтолцоотой, хариуцах эзэнтэй, хийх ажил нь тодорхой аль аль талдаа үүрэг хариуцлага нь тодорхой болох гэсэн саналтай байна.

Ш.Цолмон: За, Хууль зүй дотоод хэргийн яамыг оруулъя, манай Эрдэс баялагийн ил тод байдлын тухай хууль маань Уул уурхайн тухай хуулийн 8 дугаар бүлэг дээр орсон байгаа.

Л.Төр-Од: ТАН эвслийн санал бол тусдаа хууль батлуулах саналтай байгаа.

Ш.Цолмон: Энэ бол зарчмын асуудал юм.

Б.Энх-Амгалан: Төлөвлөгөөний 8 дугаар ажлыг хасъя. Та санхүүгийн байдлаа танилцуулах уу? Ажлын албанд хэдэн хүн ажилладаг вэ?

Ш.Цолмон: Харилцааны ажилтан, мэдээллийн зөвлөх, санхүүгийн ажилтан гэсэн 4 хүн ажиллаж байна. Энэ жил 300 гаруй сая төгрөгний ажил хийх ёстой, одоогийн байдлаар санхүүжилт жаахан гацаатай байна гэхдээ гайгүй. Бид төсөв мөнгөө харъя, тэгээд 9 дүгээр ажлыг хэвээр үлдээе.

Б.Энх-Амгалан: Ийм бага мөнгөтэй, бага төсөвтэй газар байна. Эрхзүйн хамгаалалт сайн байгаа. Санаа бодол дуу хоолой дамжихдаа сайн, санхүүжилт бага дандаа гаднын хөрөнгөөр явж байгаа. Шийдвэрийн төсөл дээр 8 дугаар ажлыг хасаад, төлөвлөгөөгөө батлах саналтай байна.

## **ХЭЛЭЛЦСЭН НЬ: ОУИТБС-ын мэдээллийг системтэйгээр ил тод болгох судалгааг үргэлжлүүлэх**

Г.Ганбат: Сайн байцгаана уу, ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын зүгээс Монгол улсын ОУИТБС-ын хүрээнд бэлтгэн гаргаж буй мэдээллийг цаашид хамаарах байгууллагуудын энгийн үйл ажиллагааны хүрээнд байнга хэвшүүлэн ил тод болгож байх бэлэн байдлыг үнэлэх энэхүү судалгааг хийж гүйцэтгэсэн. Үнэлгээний гол үр дүнд 2016 оны ОУИТБС-ын Стандартын хүрээнд ил тод болгохыг шаардаж буй ихэнх мэдээллийг хэвийн үйл ажиллагааны хүрээнд хэдийн хэвшүүлэн ил тод болгож ирснийг олж тогтоосон байна. Үйл ажиллагаанд хэвшүүлэх ажилд шилжилт хийхийн тулд Үндэсний зөвлөлд дараах үе шатуудыг даган мөрдөж, хэрэгжүүлэхийг зөвлөмж болгосон байна.

Орлогын бус мэдээлэл дээр дараах зөвлөмжүүдийг өгсөн байна. Үүнд, 1) АМГТГ нь уул уурхайн салбарын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох үйл явц, журмыг ил болгох системийг эхлүүлэх бөгөөд сонгон шалгаруулалтын шалгуур, оролцогчдын жагсаалт, үнэлгээний хорооны шийдвэр, ялагчийн нэр зэргийг Шаардлага 2.2-ын дагуу ил тод болгож, мэдээллийг нээлттэй, хүртээмжтэй форматаар ханган өгөх хэрэгтэй. 2) АМГТГ-ын кадастрын системд Шаардлага 2.3-ын дагуу өөрчлөлт хийгдэх хүртэл Монголын ОУИТБС-ын Дата порталыг өнөөг хүртэл цуглуулаад буй тусгай зөвшөөрлийн өргөдлийн огноог ОУИТБС-ын Дата порталд оруулж байх замаар түр хугацааны шилжилтийн арга хэмжээ авах шаардлагатай. Хүчин төгөлдөр буй уул уурхай, газрын тос, байгалийн хийн тусгай зөвшөөрлийн өргөдлийн огноог бүрэн гаргаж дуусах хүртэл ОУИТБС-ны тайлагналыг ашиглаж байх нь зөв юм. 3) Ерөнхий сайдын Ажлын алба болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь ашигт малтмал, газрын тос болон байгалийн хийн компаниудтай үргэлжлүүлэн ажиллах замаар олон нийтэд нээлттэй гэрээний мэдээллийн сан-гэрээний портал дээр хамаарах гэрээ, хэлэлцээрийг нийтлэх. 4) Шаардлага 2.5-ын дагуу Засгийн газар нь олборлох салбарт тусгай зөвшөөрөл эзэмшиж буй бүх компаниудын ашиг хүртэгч жинхэнэ эздийн мэдээллийг 2020 он гэхэд ил тод болгож эхлэх тул үүнийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын вебсайт эсвэл ОУИТБС-ын Дата порталаар дамжуулан хийх боломжтой. Улсын бүртгэлийн ерөнхий газрын хуулийн этгээдийн бүртгэл эсвэл АМГТГ-ын кадастрын бүртгэлийн системд суурилсан ашиг хүртэгч жинхэнэ эздийн олон нийтэд нээлттэй бүртгэл 2020 оны 1 сар гэхэд нээгдэн ажиллаж эхэлсэн байх ёстой. 5) Монгол улс нь төрийн өмчит компаниудын санхүүгийн мэдээллийг тайлагнах системийг Шаардлага 2.6 болон 6.2-ын дагуу боловсруулан гаргах, төрийн өмчит компаниуд болон Засгийн газар хоорондын санхүүгийн харилцаа, ЗГ болон ТӨК-иудын зүгээс олборлох салбарын компанид өгсөн зээл эсвэл баталгааг мөн тайлагнаж байх тогтолцоог бий болгох шаардлагатай гэсэн зөвлөмжүүдийг өгсөн байна. Орлогын мэдээлэл дээр нилээн хэдэн зөвлөмж өгсөн байгаа. Үүнд, Засгийн газрын систем болон ОУИТБС-ын Дата порталыг нэгтгэн уялдуулах чиглэлээр Засгийн газрын зөвшөөрлийг баталгаажуулах, ОУИТБС-ын Цахим тайлагналын системд богино хугацааны сайжруулалт хийх, Хараат бус аудиторов хэрэглээнээс татгалзан шилжилт хийх, ОУИТБС-ын Цахим тайлангийн систем болон Мэдээллийн порталыг УУХҮЯ-нд шилжүүлэх гэсэн зөвлөмжүүдийг өгсөн. Энэ зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхгүй бол тайлангаас ил тод болгох систем рүү шилжих боломжгүй гэж үзсэн. Эдгээр ажлыг хийхийн тулд дэд ажлын хэсэг байгуулах саналтай байна.

Б.Энх-Амгалан: За баярлалаа, ажлын албаны дотоод ажлаа төгөлдөржүүлэх ажил юм. Цаасан тайланг хүмүүс уншиж, ашиглахгүй байдаг. Үүнийг ашиглахад амар, хүнд хүрэхэд амархан болоод байна. Одоо цахим шилжилт гэж шинэ систем гарч байгаа. Бидний тайлан ухаалаг бөгөөд товч байгаад ЗГХЭГ, Уул уурхайн яам болон Гадаад хэргийн яамны сайт дээр холбуулаад тавьмаар байна. Номоор хэвлүүлэх ажлаа хийдэгээрээ хийе.

Л.Төр-Од: Бид нээлттэй засаглал хүрээлэнгийн төлөвлөгөөг хийх гэж байгаа. Өмнөх 2 жилийн ажил дуусаж байгаа. Орлогын талаарх болон орлогын бус мэдээллээ давхар оруулаад, төлөвлөгөөнд тусгаад явбал үр дүнд хүрэх магадлалтай. ЗГХЭГ-ийн

дарга Занданшатар сайд өөрөө манлайлж байгаа. Энэ дээр гурван талын оролцоотой ажлын хэсэг байгуулах саналтай байна. Би ТАН эвслээс орж болж байна, тодорхой төсөл боловсруулаад нээлттэй засгийн түншлэлд оруулвал зүгээр байна.

Б.Энх-Амгалан: Тайлан бол бидний хийсэн ажлын үр дүн юм. Үүнийг цөөн хэдэн слайд дээр багасгаад гаргамаар байна. Мөнгийг нь ажлын алба гаргачих. 20-30 слайдад тайлангаа багтаагаад өөрийнхөө болон бусад гол байгууллагуудын вэбсайт дээр байршуулъя, бусад газруудын хаяг дээр асдагаар тавьчихъя.

Ш.Цолмон: Манайх угаасаа хураангуй тайлан гаргадаг. Түүнийгээ улам хураангуй цахимаар тавихад зориулж хийе.

Б.Баярмаа: Энэ ажил маань яваандаа цаасан тайлан гаргадаг ажлыг байхгүй болгох гэж байгаа биз дээ. Бид одоо л нэг зүгшрүүлэх гэж явж байж, үүнийгээ больвол хийсэн юмнууд маань алга болчих юм биш биз?

Г.Ганбат: 2017 оны тайлан гардагаараа гарна. Энэ асуудал нь Төрийн байгууллагууд бидэнд гаргаж өгч байгаа мэдээллээ өөрсдийн вэб дээрээ байнга тавьж байх ёстой. Гарч байгаа санхүүгийн тайлангууд нь олон улсын стандартыг мөрдөж байгаа бол баталгаажуулах шаардлагагүй болох юм.

Б.Дэлгэрмаа: Сангийн яам жил бүрийн орлогын хуваарилалтыг бусдад ойлгомжгүй хэлбэрээр өгдөг, түүнийг аудитын байгууллага янзалж ойлгомжтой болгож гаргадаг. Энэ тайлангаа бусдад ойлгомжтой хэлбэрээр, маягтын дагуу гаргаад өөрсдийн цахим хуудас дээрээ байнга байршуулах хэрэгтэй болж байгаа. Бид төрийн байгууллагуудыг ийм байдлаар хийхэд нь туслаад, зохион байгуулж өгнө. Иргэн орлогын хуваарилалт харъя гэвэл Сангийн яамны сайт руу ордог, тусгай зөвшөөрлийн тухай мэдээллийг харвал Ашигт малтмал руу ордог болох юм.

Б.Баярмаа: Энийг албажуулж өгөхгүй бол болохгүй. Төрийн дарга сайд нар байнга солигддог, хичнээн жил арай гэж хийсэн ажлаа үгүй болгочихгүйгээр эрхзүйн зохицуулалтыг гаргах хэрэгтэй.

Б.Энх-Амгалан: Санал хураая, шийдвэрийн төсөл ажлын хэсгийг Зууннастаар ахлуулах гэсэн байна. Энэ хүн маань зөвшөөрөх үү?

Ш.Цолмон: Төрийн төлөөлөл ахлах ёстой. Эхлээд ахлагчийг томилж байгаа юм, дараа нь нэрсийг нь 5 сарын 15-ны дотор санал аваад оруулна.

Б.Энх-Амгалан: Манай байгууллагын вэбсайт руу хандалт хэр байдаг вэ?

Г.Ганбат: Жилдээ 10000, тайлангийн үеэр өдөртөө 30-40 хүний хандалттай.

Б.Энх-Амгалан: Энэ хэр өндөр тоо вэ?

Г.Ганбат: Яг мэдээллийн сайтын хувьд бол бага тоо, төрийн байгууллагын хувьд бол дундаждаа орно.

Б.Энх-Амгалан: Нийгмийн хэрэгцээг нь хандалтаар нь тодорхойлдог. Тэгэхээр бид эхлээд юу хийж байгаагаа хүмүүст таниулъя, хуралдаад л яваад байдаг.

Ш.Цолмон: Цогтбаатар гуайгаар тавих уу?

Цогтбаатар: амжихгүй

Ш.Цолмон: Дамба өөр ажлын хэсэгтэй байгаа, Зууннаст л одоогоор чөлөөтэй байна.


Д.Сүхбаатар: Зууннаст байх нь зүгээр, тэр угаасаа яаман дээр хариуцлагатай уул уурхай билүү тийм нийгмийн чиглэлийн ажлын чиг үүрэгтэй байдаг шиг санагдаж байна. Тэгээд ч цаадах чинь хүмүүстэй харилцаа сайтай хүн. Цогтбаатар ахаа Зууннаст өөрөө зөвшөөрч байгаа биздээ. Зөвшөөрч байгаа бол ажлын хэсгийг ахлуулах саналтай байна.

Б.Энх-Амгалан: Ажлын хэсгийг Уул уурхайн яамны ахлах мэргэжилтэн Зууннастаар ахлуулъя. Цаашдаа үйл ажиллагаагаа тогтвортой ажиллахад санхүүжилт хэрэгтэй байгаа. Та бүхэнд нийгмийн хариуцлагаа ухамсарлан хуралд идэвхтэй оролцсонд баярлалаа.

Хуралдаан 13,00 цагт өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

Ерөнхий сайдын ахлах зөвлөх,  
ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн  
нарийн бичгийн дарга, ажлын хэсгийн  
ахлагч



Б.Энх-Амгалан

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга



Ш.Цолмон

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын албаны санхүүгийн ажилтан



А.Отгонтунгалаг



Монголын "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга"-ын  
Ажлын хэсгийн 46 дугаар хуралдааны шийдвэрүүд

1. ОУИТБС-ын орон нутгийн туршилтын төслийн тухай Интерконсалтинг ХХК-ийн Адам Смит хүрээлэнгийн зөвлөх А.Михайлова, Интерконсалтинг группын төслийн багийн ахлагч С.Мягмаржав нар танилцуулсны дагуу:
  - a. Туршилтын төслийг хэрэгжүүлэхэд идэвх зүтгэл гарган, амжилттай оролцож, дэмжин ажилласан бүх хүмүүс, талуудад гүн талархал илэрхийлэх, Ажлын хэсгийн ахлагчийн гарын үсэгтэй талархалыг хүргүүлэх;
  - b. Ажлын хэсгийн гишүүдээс гарсан саналыг үндэслэн төслийг өргөжүүлэхийг зарчмын хувьд дэмжихээр тогтов.
2. ОУИТБС-ын дэд зөвлөлийн зардлын санхүүжилтын төлөвлөлт, тооцооны тухай Ажлын албаны харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаагаас танилцуулсны дагуу:
  - a. Хуралдаан дээр гишүүдээс гарсан саналуудыг нэгтгэн 2019 оны дэд зөвлөлийн төсвийн төслийг нийт 288 сая төгрөгөөр батлах нь зүйтэй гэж үзэв.
  - b. Аймаг, нийслэл, сум дүүргээр зардлын тооцоог илүү нарийвчлалттай хийж, эргэж танилцуулахыг Ажлын албанд даалгасугай.
  - c. Дэд зөвлөлийн жил бүрийн төсвийн төслийг журмын дагуу батлуулж байх арга хэмжээ авахыг Ажлын албанд даалгасугай.
3. Эрдэс баялгийн салбарт үйлчилж буй хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах тухай багц хуулийн төслийн тухай Уул уурхайн, хүнд үйлдвэрийн яамны ахлах мэргэжилтэн Ч.Цогтбаатар танилцуулсны дагуу:
  - a. Танилцуулга хийсэн УУХҮЯ-нд талархал илэрхийлэх;
  - b. Хуулийн төслийн явцын талаар Ажлын хэсэгт мэдээлэл өгч, холбогдох төлөөллүүдийг оруулж, хамтран ажиллахыг хүсэлт болгов.
4. Монголын ОУИТБС-ын 2018 оны баталгаажуулалтын дүнг бататгах ажлын төлөвлөгөөний төслийн тухай Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон танилцуулсны дагуу:
  - a. Хуралдаан дээр гишүүдээс гарсан саналуудыг нэгтгэн төслийг батлав.
  - b. Төслийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдаар батлуулан хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Ажлын албанд даалгав.
5. Бусад : "ОУИТБС-ын мэдээллийг системтэйгээр ил тод болгох" сэдвийн дагуу Ажлын хэсэг байгуулж, судалгааг үргэлжүүлэх:
  - a. Ажлын хэсгийг УУХҮЯ-ны УУБ-ын газрын ахлах мэргэжилтэн Т.Зууннастаар ахлуулан байгуулах.
  - b. Оролцогч талууд төлөөллийн нэрсээ 5 дугаар сарын 15-ны Ажлын албанд ирүүлэх

Танилцаж зөвшөөрсөн

Монгол Улсын Ерөнхий сайдын ажлын албаны дарга,  
ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга,  
Ажлын хэсгийн ахлагч

  
Б.Энх-Амгалан

Тэмдэглэсэн

Ажлын албаны зохицуулагч

  
Ш.Цолмон

Санхүүгийн мэргэжилтэн

  
А.Отгонтунгалаг